МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
Цахим шуудан: info@mcud.gov.mn,
Цахим хуудас: www.mcud.gov.mn

2023·01·25 № 3/271

танай _____-ны №_____-т

"УЛААНБААТАР ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-Д

Холболтын цэг зөвшөөрөлцөх
тухай

Эрчим хүчний яамны 2021 оны 111/2022/252 дугаар Техникийн нөхцөлийн 9.6, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын даргын баталсан 2021 оны 221/Ц-59 дугаартай зураг төсөл боловсруулах даалгаврын 3.20 дахь заалтуудыг үндэслэн "Шинэ зуунмод" хот төслийн цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд шинээр төлөвлөгдсөн бохир усны өргөлтийн насос станцын цахилгаан хангамжийн холболтын цэгийг тус яамдын холбогдох мэргэжилтнүүдийн оролцоотойгоор дараах байдлаар тодорхойлж, чиглэл өгсөн байна. Үүнд:

1. Бохир усны өргөлтийн станцын холбогдох цэгийг 110/35/10 кВ-ын "Аэро сити" дэд станцаас тэжээгдэх 10кВ-ын хуваарилах байгууламж /ХБ-3/-ийн I, II системийн шинийн нөөц ячейкаас кабель шугам татаж, 2х250 кВА дэд өртөөг тэжээх нөөц эх үүсвэр дизель генератортай төлөвлөх;

2. Цэвэрлэх байгууламжийн холбогдох цэгийг 35/10 кВ-ын "Хөндий" дэд станцын 35кВ-ын ил хуваарилах байгууламжийг 2 гаргалгаар өргөтгөн агаарын болон кабель шугам татаж, 2х2500 кВА дэд станцыг тэжээхээр трассыг сонгох.

3. Энэ чиглэлийн дагуу "Наран рашаан" ХХК нь Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ болон "Некстстеп инженеринг" ХХК-тай зөвшилцөж ажлын зураг төслийг боловсруулж байна.

Иймд 10кВ-ын кабель шугам, 35кВ-ын агаарын шугамын холболтын цэгүүдийг танай байгуулллагатай эцэслэн зөвшөөрөлцөхөөр трассын зургийг хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: "Наран рашаан" ХХК-д

Хавсралт ... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.МАГНАЙСҮРЭН

152350469

БАТЛАВ. АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА Т.БАТДОНДОГ

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг байгуулагдах "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн эхний ээлжийн барилга байгууламжийн цахилгаан хангамжийн

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо. 2022.05.25 № 71/2022/96 Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг	***"БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ"*** *Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр*
2. Техникийн нөхцөл хүссэн байршил	*Төв аймаг, Сэргэлэн сум*
3. Ажил үйлчилгээний зориулалт	*Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн эхний ээлжийн барилга байгууламжийн цахилгаан хангамж*
4. Техникийн нөхцөл олгох, сунгах үндэслэл	*- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлогын эхний үе шатны хөтөлбөр",* *- Монгол Улсын Их Хурлын 2022 оны 10 дугаар тогтоол,* *- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,* *- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоол, түүний хавсралтаар батлагдсан "Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө,* *- Барилга хот байгуулалтын яамны 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 03/2469 тоот албан бичиг болон түүний хавсралтууд,* *- "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК-ийн 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 02/802 тоот албан бичиг, горимын тооцооны дүгнэлт,* *-Эрчим хүчний сайдын 2022 оны А/96 дугаар тушаалаар байгуулагдсан "Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэж шийдвэрлэх ажлын хэсэг"-ийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн товч тэмдэглэл*
5. Олгосон чадал	*35 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10 кВ-ын 2х10000 кВА хүчин чадалтай*

	дэд станц, 10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, 10/0.4 кВ-ын дэд станцууд
6. Тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага	*6.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.* *6.2 RS-485-ийн холболтын протоколтой, олон улсын IEC61107, IEC62056 стандартуудын шаардлага хангасан,* *6.3 Санах ой бүхий 0.2 нарийвчлалтай бүрэн электрон тоолуур суурилуулах.* *6.4 Шинээр суурилуулж буй тоолуурууд нь тоолуурын нэгдсэн системд холбох.*
7. Гүйдлийн трансформаторт тавигдах шаардлага	*7.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.* *7.2 Холбогдох тооцооны дагуу ачаалал хэрэглээнд тохирсон коэффициент бүхий гүйдлийн трансформатор суурилуулах.* *7.3 Олон улсын IEC 61861 стандартын шаардлагыг хангасан, реле хамгаалалт, хэмжүүр, хянах хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан, 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор суурилуулах,*
8. Холбогдох цэг	*8.1 Шинээр баригдах 110/35/10 кВ-ын "Шинэ Зуунмод" дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийг 2 гаргалгаагаар өргөтгөн, 35 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10 кВ-ын дэд станцыг тэжээх.* *8.2 Шинээр баригдах 110/35/10 кВ-ын "Шинэ Зуунмод" дэд станцыг ашиглалтад орсоны дараа холбогдох.*
9. Дамжуулах, түгээх сүлжээний шугам, дэд станцыг өргөтгөх шаардлага	***9.1 110/35/10 кВ-ын "Шинэ Зуунмод" дэд станцын өргөтгөл:*** *9.1.1 Дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийг олон улсын стандартын шаардлага хангасан гүйдэл, хүчдлийн трансформатор, олон улсын IEC стандартын шаардлага хангасан алсын удирлагатай вакуум таслуур, газардуулгын хутга бүхий хуурай салгуур, цэнэг шавхагчаар тоноглон өргөтгөх.* *9.1.2 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн шин, дамжуулагч утас, изоляторууд болон бусад цахилгаан тоноглолуудыг зураг төслийн шатанд тооцоогоор сонгож, ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК-тай зөвшилцөх,* *9.1.3 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн шин, оруулга, гаргалгааны үндсэн болон бэлтгэл хамгаалалтуудыг тооцоо хийж, ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК-тай зөвшилцөн сонгох, шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх,*

9.1.4 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийг өргөтгөж байгаатай холбогдуулан, зураг төсөл боловсруулах шатанд дэд станцын аянгын хамгаалалт, газардуулгын байгууламжийн тооцоо, хэмжилтийг хийж, тогтоосон дүрэм журмын шаардлагад хүргэх.

9.1.5 Дэд станцын өргөтгөлийн ажлын зураг төслийг боловсруулах шатанд ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК-тай зөвшилцөн, батлуулах.

9.2 Шинээр баригдах шилэн кабель бүхий 35 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам:

9.2.1 35 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам нь MNS 6522:2015 стандартын шаардлага хангасан байх,

9.2.2 Дамжуулагчийн хөндлөн огтлолыг ачаалал, хэрэглээтэй уялдуулан сонгох, мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг тооцоогоор сонгох,

9.2.3 Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр, төмөр бетон байх,

9.2.4 Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийцүүд, дамжуулагч утас, шилэн кабель бүхий аянгын тросс, хөндийрүүлэгч элементүүд, утас угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухай газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох,

9.2.5 Цахилгаан дамжуулах агаарын шугаманд сүүлийн үеийн микро процессор бүхий үндсэн болон бэлтгэл хамгаалалт, газардлагын хамгаалалтыг суурилуулах, дэд станцын удирдлагын өрөөний удирдлага хяналтын төхөөрөмжинд (HMI) холбох,

9.2.6 Шинээр суурилуулах тоолууруудыг тоолуурын нэгдсэн системд холбох.

9.2.7 Цахилгаан дамжуулах агаарын шугамын трассыг одоо байгаа болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төслийн шатанд ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөн сонгох,

9.3 35/10 кВ-ын "Хөндий" дэд станц:

9.3.1 Дэд станц нь 35/10 кВ-ын 2х10000 кВА хүчин чадалтай трансформатортай байх,

9.3.2 35/10 кВ-ын трансформатор нь ачаалалтайгаар хүчдэл тохируулагч /РПН/-тай байх. РПН-ны тавилыг автоматаар өөрчлөх төхөөрөмж суурилуулах ба тогтмол гүйдлийн хэлхээнээс тэжээгддэг байх, Хэвийн хүчдлийн 1.25-аас багагүй, 1.6-аас ихгүй хэмжээтэйгээр өөрчлөх боломжтой, 5-аас доошгүй тавилтай байх,

9.3.3 Дэд станцын трансформатор нь олон улсын IEC 60076-10 стандартын шаардлагыг хангасан байх,

9.3.4 Шинээр тавигдах 35 кВ-ын хүчний трансформаторын оруулганд тооцоогоор цэнэг шавхагч сонгож суурилуулах,

9.3.5 Трансформаторын хөргөлтийн систем нь үлээлгэн болон тосон хөргөлттэй байх,

9.3.6 Трансформаторын чадалд тохирсон 35 кВ, 10 кВ-ын шинийн утас, түүний механик ачаалалд тохирсон шинийн порталь, тусгаарлагч элемент, дагалдах төмөр хийцүүдийг тооцоогоор сонгох,

9.3.7 Трансформаторын суурийн тооцоог зураг төслийн шатанд хийж, барилгын мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан, түүнийг үндэслэн суурийг хийж гүйцэтгэх,

9.4 Дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламж:

9.4.1 35 кВ-ын ил хуваарилах байгууламж нь I II систем шин, секц холбогч таслуур бүхий схемтэй байх, Зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх,

9.4.2 35 кВ-ын шинийн утсыг тооцоогоор сонгож, утасны механик ачаалалд тохирсон шинийн порталь, тусгаарлагч элемент, дагалдах төмөр хийцийг тооцоогоор сонгох,

9.4.3 35 кВ-ын гаргалгаа тус бүрт IEC стандартын шаардлага хангасан сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий фаз тус бүрийн удирдлагатай элегаз таслуур болон дагалдах тоноглолын хамт, газардуулгын хутга бүхий алсын удирдлагатай цахилгаан соронзон хоригтой хуурай салгуур бүхий тоноглолууд суурилуулах, цаашид өргөтгөх боломжтой байхаар зураг төсөлд тусгах,

9.4.4 35 кВ-ын систем шин нь трансформаторын 2, шугамын 2 гэсэн ячейкуудтай байх бөгөөд цаашид өргөтгөх боломжтой байхаар төлөвлөж зай талбайг зурагт тусгах,

9.4.5 35 кВ-ын гаргалгааны таслууруудыг АПВ төхөөрөмжөөр болон удирдлагын түлхүүрээр /гараар/ синхрон хяналттай залгах боломжтой байх. Синхрон хяналтын мэдээллийг /шугам, шинийн хүчдэл, өнцөг, давтамж/ хүчдлийн трансформатороос авч байх.

9.4.6 АПВ-гийн төхөөрөмжийг шугамын хүчдэл ба шинийн хүчдэл хянах боломжтойгоор сонгох

9.4.7 35 кВ-ын гаргалгаанууд болон трансформаторуудын гаргалгаа тус бүрт ачаалалд тохирсон коэффициент бүхий гүйдэл, хүчдэл, бодит, хуурмаг чадлын хэмжүүр тавих,

9.4.8 35 кВ-ын хуваарилах байгууламжийн шинийн болон шугам, трансформаторуудын үндсэн, бэлтгэл хамгаалалтуудыг олон улсын IEC-61000, IEC-60258, IEC-60068, IEC-61850 зэрэг стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох тооцоонуудыг хийж сонгох,

9.4.9 Үндсэн болон бэлтгэл хамгаалалтууд нь тусдаа бие даасан реле болон тэжээлийн блоктой, IP55 стандартын шаардлага хангасан хамгаалалтын панель дээр суурилагдсан байх,

9.4.10 Реле хамгаалалт автоматикуудын тавил тооцоог "Баянхонгор эрчим хүч цахилгаа түгээх" ТӨХК-аар хийлгэн, хянуулах,

9.4.11 Дэд станцын технологийн процессыг хянах, удирдах автомат систем удирдлага, хяналтын систем /HMI/-тэй байх,

9.4.12 Аваарийн үеийн процессыг бүртгэх төхөөрөмжөөр тоноглох,

9.5 Дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламж:

9.5.1 Дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламж нь 10 кВ-ын секцлэгдсэн шин бүхий схемтэй, трансформаторын оролт, дотоод хэрэгцээний трансформатор, гүйдэл, хүчдлийн трансформатор, хуурай салгуур гэсэн тус бүртэй ячейктай байх ба гаргалгааны тоог хэрэглээ ачаалалтай уялдуулан сонгох, Зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх,

9.5.2 10 кВ-ын хуваарилах байгууламжийн кабелийн туннель, тоноглолд засвар үйлчилгээ хийх зай талбайг норм дүрмийн шаардлагад нийцсэн байхаар зураг төсөлд тооцох,

9.5.3 10 кВ-ын хуваарилах байгууламжийн бүх ячейкийг сүүлийн үеийн олон улсын стандартын шаардлага хангасан компьютерийн удирдлага хяналтын системээр хянадаг, вакуум таслуур бүхий иж бүрэн ячейкуудыг суурилуулж, хэмжилт туршилт хийж бүрэн ажиллагаанд оруулах,

9.5.4 10 кВ-ын секц тус бүрт хүчдлийн трансформатор, цэнэг шавхагч, тулгуур изолятор, газардуулгын хутга бүхий алсын удирдлагатай хуурай салгуур бүхий тоноглолуудаар иж бүрэн тоноглох,

9.5.5 10 кВ-ын ячейк нь олон улсын IEC-61850 цуврал стандартын шаардлага хангасан микропроцессорын реле хамгаалалттай, механик болон цахилгаан хоригтой, автомат болон механикаар залгаж, таслах үйлдэл хийх пуршин дамжлага бүхий нумын хамгаалалт, газардлагын хамгаалалтын функц, шинийн логик хамгаалалттай байх,

9.5.6 Шинээр суурилагдах ячейк нь халаагуурын систем, температурын датчик, кабелийн холболтын камерт нумын хамгаалалт, газардуулгын дохиолол, фазын дараалын индикатортай, ячейкны ар талаас кабелийн үзүүр, гүйдлийн трансформаторт үзлэг шалгалт хийх цонх зэргээр тоноглогдсон байх,

9.5.7 Шинээр суурилуулах ячейкуудад хэрэглэгчийн ачаалалд тохирсон коэффициент бүхий 0.2 нарийвчлалттай гүйдлийн трансформатор, кабелийн үзүүрт тооцооны үндсэн дээр хэт хүчдэл хязгаарлагч /ОПН/ сонгох, Кабелийн туннель болон ячейкуудад тэсэрдэг галын хор байрлуулах /Бурон-2.0, ОСП-1/

9.5.8 Ячейкуудын гүйдлийн трансформаторын коэффициентийг хэрэглээ, ачаалалтай ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөж сонгох,

9.5.9 10 кВ-ын хатуу шинийг тооцоогоор сонгож хийх,

9.5.10 10 кВ-ын ячейкуудад реле хамгаалалтын тооцоог хийж, тавил тохируулах,

9.5.11 10 кВ-ын хуваарилах байгууламжийн барилгыг барьж цаашид шинээр ячейк нэмж суурилуулахаар өргөтгөх боломжтой байх. Хуваарилах байгууламжийн гэрэлтүүлэг, халаагуурыг сүүлийн үеийн эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж сонгох,

9.5.12 10 кВ-ын тоног төхөөрөмжүүдийн суурилуулалт болон газардуулгыг техник ашиглалтын норм, дүрмийн шаардлагад нийцүүлэх,

9.6 Шуурхай ажиллагааны холбоог орчин үеийн технологид суурилагдсан холбооны төхөөрөмжөөр тоноглож, "УБЦТС" ТӨХК-тай диспетчертэй холбох, Зураг төслийн явцад зөвшилцөх,

9.7 Дэд станцын гэрэлтүүлэг, аянга хамгаалалтын зон, газардуулгыг техник ашиглалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан байх.

9.8 Дэд станцад хяналтын камер, дуут дохио, шуурхай ажиллагаа явуулах радио станцаар тоноглох.

9.9 Ашиглалт, шуурхай үйлчилгээ, удирдлагын байр /ОРУ, ЗРУ/ барьж, шуурхай үйлчилгээний холбоо, ажлын болон аваарийн дохиололууд, компьютерийн удирдлага бүхий удирдлагын панелиар тоноглох,

9.10 Чөлөөт бүсийн эхний ээлжийн барилга байгууламжийн цахилгаан хангамжид 35/10 кВ-ын дэд станцын 10 кВ-ын ХБ-аас ачаалал хэрэглээнд тохирсон 10 кВ-ын цахилгаан дамжуулах хос кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд станц /ХТП маягийн/ барих. Зураг төсөл боловсруулах шатанд холболтын схем, горим ажиллагааг ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөн батлуулах,

9.11 10 кВ-ын цахилгаан дамжуулах хос кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд станц /ХТП маягийн/-үүдийн хүчин чадлыг зураг төсөл боловсруулах шатанд тооцоогоор сонгож, ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх.

9.12 Шинээр суурилуулж буй тоноглолууд нь Монгол орны цаг уурын нөхцөл, далайн түвшний өндөрлөг, IEC стандарт, техник ашиглалтын дүрмийн шаардлага хангасан байх бөгөөд өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, ±10%-ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах,

9.13 Галын хор, щит, самбар, пунктыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах

9.14 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх

	9.15 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-уудад хүлээлгэн өгөх,
10. Реле хамгаалалт, автоматикийн байгууламжид тавих шаардлага	*10.1 Энэхүү техникийн нөхцлийн дагуу суурилуулах реле хамгаалалт, автотикийн тоног төхөөрөмжүүд, удирдлага, хяналт, мэдээллийн системүүд нь "Бодлогын бичиг баримт батлах тухай" Эрчим хүчний сайдын 2019 оны 335 дугаар тушаалаар батлагдсан "Реле хамгаалалт, системийн автоматикийн талаар баримтлах бодлогын баримт бичиг", "Эрчим хүчний салбарт баримтлах мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг"- шаардлагуудыг бүрэн хангах, хангагч байгууллага "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-уудтай зураг төсөл боловсруулах шатанд зөвшилцсөн байх.*
	10.2 Хуваарилах байгууламж, шугам, дэд станцын оруулга, гаргалгааны тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж, ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөн сонгох.
	10.3 Реле хамгаалалт автоматикийн тавилын тооцоог хангагч байгууллага "УБЦТС" ТӨХК-аар хийлгэх.
11. Реактив чадлын зохицуулалт	-
12. Цахилгаан эрчим хүчний чанарыг хянах хэрэгсэл, чанарын үзүүлэлтийг тогтворжуулах төхөөрөмжийн хэрэгцээ	-
13. Нэг маягийн зураг төсөл хэрэглэх зөвлөмж	*13.1 Зургийн даалгаврыг Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газраас авах.*
	13.2 Ажлын зураг төсөл боловсруулахдаа Монголын Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллага болон ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцсөн байх.
	13.3 Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг, ячейкны дугаар, шуурхай ажиллагааны нэр, зарчимын схем, хоёрдогч хэлхээний зургийг ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх.
14. Гэнэтийн гэмтэл саатал, аваарийн үед ашиглах бэлтгэл тэжээл, бие даасан цахилгааны үүсгүүр суурилуулах шаардлага	-
15. Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүйн ажиллагааны байдал	*15.1 "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.8 "Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах" гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.*

16. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа	*16.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.9-д заасны дагуу 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл /1 жилийн хугацаанд/ хүчинтэй.* *16.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн* ***2.13, 2.16-д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.***
17. Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам	*17.1 Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд орон зайн мэдээллийг оруулах,* *17.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад трассын дагуу дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах,* *17.3 Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг "Цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм" (2003 он), Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх "Тусгай зөвшөөрөл" бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх,* *17.4 "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 "Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй" гэж заасны дагуу өөрийн тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.*
18. Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох заалт	*18.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.* *2.17 дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:* *2.17.1. хүчинтэй хугацаа дууссан;* *2.17.2. техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;* *2.17.3. холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн;* *2.17.4. дамжуулагчаас санал аваагүй, өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн.* *18.2 Олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд*

АЖЛЫН ХЭСГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЖЛЫН ХЭСГИЙН ОРЛОГЧ ДАРГА:

ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Ш.ГАНЗОРИГ

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

"ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК-ИЙН ЕРӨНХИЙ ДИСПЕТЧЕР Б.БААТАР

"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Б.ДАШДАВАА

"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ М.ГАНСҮХ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ:

Хүсэлт гаргасан иргэн буюу хуулийн этгээдийг төлөөлж:

Хүлээн авч, техникийн нөхцөлийн заалтууд, тухайн техникийн нөхцөл хүчингүйд тооцох заалттай танилцсан эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Нэр:..... Гарын үсэг: .....

Регистрийн дугаар: .....

Холбоо барих: .....

Огноо: